

ГАРЧИГ

| | |
|---|-------|
| • Төслийн товч танилцуулга | 2-8 |
| • Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | 9-17 |
| • Байгаль орчны менежментийн гол зорилт, хамрах хүрээ | 18 |
| 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 18-22 |
| 2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 23 |
| 3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө..... | 23 |
| 4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | 23 |
| 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө..... | 23 |
| 6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө..... | 24-25 |
| 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 26-31 |
| 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 32-33 |
| 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр..... | 35-37 |
| 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь..... | 37 |


Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших “БЛАСТ” ХХК-ний Нарийн сухайтын эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулхын цогцолбор

Төслийн газар зүйн байрлал:

Тус цогцолбор нь Улаанбаатар хотоос баруун урагш 900 гаруй км, Даланзадгад хотоос зүүн урагш 320 км, Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас зүүн урагш 35 км, Шивээ-Хүрэн боомтоос 50 км зайд Нарийн сухайт нүүрсний орд газарт байрлана.



Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулхын цогцолборын байршил

Төсөл хэрэгжүүлэгчийн товч танилцуулга

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний “Бласт”ХХК нь үйлдвэрлэлийн тэсрэх материалын хангамж, тэсрэх бодисын үйлдвэрлэл, тэсрэх материалын хадгалалт, тээвэрлэлт, тэсэлгээний ажлын үйлчилгээ эрхэлдэг улсдаа томоохон компанийн нэг юм. “Бласт”ХХК нь 2001 онд байгуулагдсанаасаа хойш дээрх үйл ажиллагааг 21 жил тасралтгүй эрчимтэй явуулж байгаа үндэсний компани юм.

Төсөл боловсруулагчийн товч танилцуулга

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийн сухайт орд газарт байрлах Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулхын цогцолбор нь 2009 онд байгуулагдсанаас хойш тэсрэх бодисын үйлдвэрлэл, тэсрэх материалын хадгалалт, тээвэрлэлт, тэсэлгээний ажлын үйлчилгээ явуулдаг болно

Тэсрэх бодис үйлдвэрлэлийн ерөнхий ойлголт

Задгай эмульсийн тэсрэх бодис:

Үл холилдох хоёр шингэн нэг нь нөгөөдөө жигд тархсан систем юм. Усан ба тосон уусмалын нэгдэл бүхий усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодис нь гадаад байдлаараа зуурмаг, шингэн төлөвт байх ба тэсрэлтийн чадал болон бусад үзүүлэлт, хэрэглэх нөхцөл, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааны нэгдүгээр ангилалд хамаарна.

Энгийн найрлагатай тэсрэх бодис:

Энгийн найрлагатай тэсрэх бодис /цаашид ANFO гэх/ нь сүвэрхэг аммиакийн шүү ба шатах хольцоос тогтсон тэсэлгээнд зориулсан өртөг багатай тэсрэх бодис юм. Хэрэглэгчийн хүсэлтийн дагуу /ANFO/-ыг зориулалтын холигч цэнэглэгч авто машинаар тэсэлгээний талбайд бэлтгэнэ.

Энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис:

Энгийн тэсрэх бодисын хүчийг нэмэгдүүлэх зорилгоор энгийн тэсрэх бодисыг хольж энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис болгодог. Хольц нь ANFO-ны орцын хувиас хамааран 2 төрөл байна. ANFO нь 50-иас бага хувиар орвол энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис /BLEND/ юм. ANFO нь 50-иас их хувиар орвол хүнд анфо буюу /Heavy ANFO/ болно. Дээрх 2 төрлийн хольцыг үйлдвэр болон тусгай зориулалтын цооног цэнэглэгч авто машинд бэлтгэж, үйлдвэрлэнэ.

Төслийн барилга байгууламж

Үйлдвэр цогцолборын барилга байгууламж:

Өмнөговь аймгийн Гурвантэс суманд байрлах эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулхын цогцолборын тэсрэх бодисын үйлдвэрийн барилга байгууламжийн төлөвлөгөөг үйлдвэрийн хүчин чадал, хэрэгцээ болон үйлдвэрийн шаардалагтай аюулгүйн зай талбайн хэмжээнд тулгуурлан боловсруулав. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн цогцолборт доорх барилга байгууламжууд байх бөгөөд нийт 2 га талбайг хамарна.



Үйлдвэр агуулхын цогцолбор

Америк технологитой эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр №1:

Хүчин чадал: 120тн/хоногт

Ашиглалтанд орсон он: анх БНХАУ технологитойгоор 2010 онд орсон /2018 онд өргөтгөл хийж АНУ технологитой болгон өөрчилсөн/



Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр №1

Америк технологитой эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр №2:

Хүчин чадал: 120тн/хоногт

Ашиглалтанд орсон он: 2012 он



Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр №2

Химийн бодисын агуулах:

Химийн бодисын агуулах №1 урт нь 66м, өргөн нь 12м бөгөөд 6 тасалгаатай.

Химийн бодисын агуулах №2 урт нь 60м, өргөн нь 12м бөгөөд 5 тасалгаатай.



Химийн хорт болон аюултай бодисын агуулах


Агуулах цогцолборын барилга байгууламж:

Агуулхын цогцолбор нь тэсрэх материалын болон Химийн хорт болон аюултай бодисын агуулах гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Агуулхын цогцолбор нь нийт 3 га талбайг хамарна.

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн дагуу тоноглож дотролсон агуулхад дүрмийн дагуу тэсрэх материалыг хадгална.



Тэсрэх материалын агуулах



Тэсрэх материалын агуулах

Ажилчдын хотхоны барилга байгууламж:

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулхын цогцолборын ажилчдын хотхон нь нийт 0.420 га талбайг хамарна. Ажилчдын хотхон нь ажилчдын амарх байр, хоолны газар, авто гараж, спорт зал, харуулын байр барилгуудаас бүрдэнэ. Мөн ажилчдын амрах байрны өргөтгөлийн зориулалтаар 0,41 га газарыг 2019 онд эзэмшиж байна.

Ажилчдын хотхон нь 1 ээлжиндээ 100 хүн хүлээж авах хүчин чадалтай. Өрөө бүр цонх, ариун цэврийн өрөө, угаалтуур, шүршүүртэй бөгөөд 2-4 хүн нэг өрөөнд байхаар тооцсон.



Ажилчдын хотхон

Бусад эзэмшиж буй газрын мэдээлэл:

- Сайжруулсан зам /тэсрэх материалын агуулах/ нийт 1,2га
- Сайжруулсан зам /эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр/ нийт 0,45га
- Сайжруулсан зам /ажилчдын хотхон/ нийт 2,6га
- Өндөр хүчдэлийн шугам /үйлдвэр/ 200м
- Өндөр хүчдэлийн шугам /тэсрэх материалын агуулах/ 200м

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэсний дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “хамааралгүй” гэж бөглөнө.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|-----|--|---|
| 1.1 | 1.Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэр | “Бласт” ХХК |
| | 2.Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн дугаар | 9011125047 |
| | 3.Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл | Тэсрэх материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, импортлох, худалдаалах |
| | 4. Аж ахуй нэгжийн харьяаллын хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө-13,3 дугаар давхар |
| | 5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг | Гүйцэтгэх захирал А.Тэмүүлин 99112528 temuulen@blastcompany.mn |
| | 6. Салбарын дарга нэр, утас, цахим шуудангийн хаяг | Нарийн сухайт салбарын дарга Г.Гантулга 99003490 G.Gantulga@blastcompany.mn |
| | 7. Хариуцсан мэргэжилтэн, нэр, утас, цахим шуудангийн хаяг | Байгаль орчны мэргэжилтэн: Д.Болортуяа 99293035 Bolortuya.d@blastcompany.mn |
| 1.2 | Төслийн нэр | Нарийн сухайт салбар (Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулах цогцолбор) |
| | Төслийн нэр харьяаллын байршил | Өмнөговь аймаг, Гурвантэс сум, Урт баг |
| | Төслийн ангилал | Үйлдвэр |
| | Төсөл эхэлсэн огноо | 2009.05 |
| | ТЭЗҮ батлагдсан огноо | 2018 он |
| | Урьд оны бүтээгдхүүний хэмжээ | Anfo - 4,500,000кг, Blend – 20,000,000кг |
| | Ажилчдын тоо нийт | Бласт - 120, Гэрээт - 36 |
| | Тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэрийн хүчин чадал | 240тн/хоногт |

Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгогддог тусгай зөвшөөрөл, дүгнэлт, лавлагааны товч мэдээлэл

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах
- Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтэд тусгагдсан холбогдох хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

| Д/д | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|-----|---|--|
| | Үйл ажиллагааны эрхлэх зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа | Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, ажил үйлчилгээ хийх 398 2019 оны 12 сарын 17 өдөр /3жил/ |
| | Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах, тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай хуулийн дагуу олгосон холбогдох зөвшөөрөл бусад бичиг баримтууд/ Дугаар Хүчинтэй хугацаа | Химийн хорт болон аюултай бодис экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл 0001154 2021.12.13 – 2024.12.31 |
| | Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт | 2018.01.29-ний өдрийн хурлаар авсан. Дүгнэлт гаргасан: Байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Баттулга |
| | Галын аюулгүй байдлын зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа | Үйлдвэр 0003400 2023.12.15 |
| | Галын аюулгүй байдлын зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа | Тэсрэх материалын агуулах 01910835 2023.12.15 |
| | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд | 2023 он БОНХЯ-ны ерөнхий шинжээч Г.Энхмөнх |
| | Ус ашиглалтын дүгнэлтийн огноо | |
| | Байгаль орчны аудит | “Энвайроментал Комплајц”ХХК 2021 онд |
| | Газрын төлөв байдал чанарын хянан магадалгаа, огноо, баталсан хуулийн эдгээд | 2022.04.28 он Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /ой усан сан бүхий газрын мониторинг, нөхөн сэргээлт хариуцсан иэргэжилтэн/ Ууганзаяа |

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлт

Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- *Төслийн үйл ажиллагаанаас буюу үйлдвэрт хэрэглэгдэж буй химийн бодисууд ямар нэгэн байдлаар газрын гадарга руу алдагдсан газрын хэвлийн болон түүний гадаргыг бохирдуулж болзошгүй*
- *Хүний буруутай үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааны дүрмийг чанд баримтлан ажиллаагүйгн улмаас химийн бодисын агуулах, тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодисын агуулах зэрэг зэрэгт осол-аюул гарснаар газрын гадаргад ноцтой аюул, гамшиг, бохирдол үүсгэж болзошгүй*
- *Байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн бодис, тэсрэх бодис газрын гадарга, хөрсөнд хаягдаж болзошгүй*
- *Байгалийн гэнэтийн аюултай үзэгдлийн улмаас химийн бодисын агуулах, тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодисын агуулхад осол-аваарь гарснаар газрын гадаргад ноцтой аюул, гамшиг, бохирдол үүсгэж болзошгүй*
- *Тэсрэх бодисын үйлдвэрийн машин, техникийн ашигласан тос алдагдан газрын гадарга бохирдуулж болзошгүй*
- *Химийн бодис болон түүний сав баглаа боодлын хаягдлыг зохих дүрмийн дагуу зайлуулж, устгаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй*
- *Ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын зохих дүрмийн дагуу зайлуулаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй*

Агаар орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Тэсрэх бодисын үйлдвэрт хэрэглэгдэх химийн бодисуудаас агаарын чанарт цөөн хэдэн хүчин зүйлсээр болзошгүй нөлөөлөл үзүүлэхээр байна. Энэ нь химийн бодисуудыг ашиглах, тээвэрлэх, хадгалах болон тэдгээрийн хаягдлыг устгах үед болон ажлын байрны агаарын чанар, найрлагыг өөрчилж болзошгүй байдлаар тодорхойлогдоно. Төслөөс тухайн нутгийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- *Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршилттай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалдаж, салхиар тарах зэргээр чанар найрлагыг өөрчлөх*
- *Химийн бодис, түүний сав баглаа боодлын хаягдлыг шатаах аргаар устгах үед хорттой хий ялгаран агаарын чанарт сөргөөр нөлөөлнө*
- *Хог хаягдлын зохисгүй хадгалалт, зохион байгуулалтаас агаар орчин бохирдох*
- *Болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах хорт хийн дэгдэлт агаарын чанарт нөлөөлөх зэрэг болно*
- *Төслийн бүс нутгийн уур амьсгалын эрс тэс байдал нь химийн бодисын хадгалалтын горимыг алдагдуулах нөлөөлөл үзүүлж болзошгүй юм*

Гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Төслөөс тухайн нутгийн гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- *Төслийн үйл ажиллагааны үед хөрсний болон газрын гадаргын усны нөөц, түүний чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд нь хаягдал бохир ус болон, шатах, тослох материалын хаягдлаар бохирдож болзошгүй байна*
- *Олон машин механизмын зүй бус ашиглалтаас бензин, дизель болон бусад хорт бодис гоожих эсвэл алдагдсан нөхцөлд хөрс, орчмын ургамлын бүрхэвчид сөргөөр нөлөөлж улмаар хөрсөнд нэвчин гүний усыг бохирдуулах болзошгүй*
- *Төслийн талбай орчинд хэд хэдэн хуурай сайр байгаа нөхцөлд аадар борооны үед усжин үер буух нөхцөлтэй*
- *Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас үүдэн гадаргын болон газрын доорх ус бохирдож болзошгүй*
- *Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн хорт бодисоор гадаргын болон газрын доорх ус бохирдож болзошгүй*

Хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Тус төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь химийн бодис, шатах тослох материал, тос тосолгооны материал асгарах, алдагдах болзошгүй нөлөөлөл байна.

- *Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас үүдэн хөрс бохирдож болзошгүй*
- *Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын норм алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн хорт бодисоор хөрс бохирдож болзошгүй*
- *Химийн бодис болон ахуйн гаралтай хог хаягдлын зохисгүй хадгалалт, зохион байгуулалтаас хөрс бохирдох*
- *Болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах үнсний дэгдэлт, химийн бодисын алдагдлаас хөрс бохирдож болзошгүй болно.*

Ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Үйлдвэр орчмын ургамлан нөмрөг зарим төрлийн осол аваар, техникийн ажиллагааны алдаанаас шалтгаалан шууд болон дам сөрөг нөлөөлөлд өртөх магадлал байна. Үүнд:

- *Тээвэрлэлтийн болон хаягдал устгалын үеийн осол аваарийн үед химийн бодис болон техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлж, бохирдуулах*
- *Гал, ослын үед дэгдэн хорт утаа хур тунадасаар дамжин ургамалжилтанд нөлөөлөл үзүүлж, тэжээлээр дамжин мал, амьтад хордох*
- *Химийн бодис болон шатах тослох материалаар хөрс бохирдсоноос шалтгаалж ургамал ургах нөхцөл буурах*
- *Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас үүдэн ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй*

Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Төслөөс амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- *Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтдад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө*
- *Хууль бус ан агнуур ихсэж болзошгүй*
- *Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас амьтад хордож болзошгүй*
- *Болзошгүй галын аюул, осол аваарийн үед гарах үнсний дэгдэлт, химийн бодисын алдагдлаас амьтад хордож болзошгүй болно*

Гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосонцор болон хийнүүд нь салхиар зөөгдөж тухайн газар орчмын агаарыг бохирдуулахаас гадна орон нутгийн байгаль орчин, хүн, амьтанд зохисгүй нөлөөлдөг. “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт сөргөөр нөлөөлөх үндсэн 3 нөлөөлөл байна. Үүнд:

- *Төсөлд ашиглагдаж байгаа машин механизм, дизель станциас ялгарах бохирдуулагч бодисууд*
- *Төслийн талбай болох химийн бодисын агуулахнуудын хамгаалалтын далангаас тоос дэгдэж агаар орчинд тархана*
- *Тэсрэх бодисын үйлдвэрийн цогцолборт нэмж баригдах барилгын ажлаас үүдэн агаар мандалд гарах тоосны хэмжээ нэмэгдэх, зөөгдөх*

- *Үйлдвэрийн түүхий эд болон бүтээгдхүүнийг тээвэрлэхэд агаар мандалд гарах тоосны хэмжээ хуурайшлын үед нэмэгдэх, зөөгдөх*
- *Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдэх нь агаарын чанар, шуугианы бохирдлын түвшинг ихэсгэнэ*
- *Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдал агаар орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.*

Уурын зуухнаас гарах угааны тархалт

“Бласт” ХХК-ийн бодисын хольцын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төсөл нь 2 уурын зуух ашигладаг болно. Эдгээр уурын зуухны ажиллагааны үед яндангаас нь угаарын хий (CO), хүхрийн давхар исэл (SO₂), азотын давхар исэл (NO₂), аэрозол болон бусад бодис ялгарч хүрээлэн буй байгалт орчны агаарын чанарт тодорхой хэмжээний сөрөг нөлөөллийг үзүүлнэ.

Уурын зуухнуудын яндангаас гарах бохирдуулагч бодисын хүрээлэн буй орчин дахь тархалтыг доорх өгөгдлүүдэд үндэслэн тооцоолов. Үүнд:

- *Нэг уурын зуух нь өдөрт 0,9-1,0 тн нүүрс хэрэглэдэг*
- *Өвөл 24 цаг, зун ажлын цагаар буюу 8-12 цаг ажилладаг*
- *Яндангийн өндөр 12м, диаметр 30 см*
- *Салхины хурд дунджаар: 4,2-4,3 м/сек (олон жилийн мэдээний дундаж)*
- *Салхины зонхилох чиглэл: баруун, баруун хойд, хойд зүгээс*

Дуу чимээ, шуугиан

Тухайн төслийн хувьд дуу чимээ, шуугианы бохирдлын 82-85 ДБ дууны даралт үзүүлдэг дизель цахилгаан үүсгүүр, техникийн засвар үйлчилгээ, гагнуурын ажил зэрэг нь тус тус хамаарна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед шуугианы эрчим дунд зэрэг бөгөөд хугацааны хувьд тогтмол байна. Эх үүсвэрээс чимээ шуугиан нь ил задгай агаарт чөлөөтэй тархана.

Шуугианы дууны даралт тавтамжаас хамаарч харилцан адилгүй үүсдэг тул шуугианы тархалтын тооцоог 31.5-8000 Гц-ын давтамжийн хооронд хийнэ. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед үүсэх шуугианы тархалтын тооцоог “Шуугианы хамгаалалт” БНБД 23-03-2003, нормативийн дагуу хийв. Тооцооны дагуу дизель генераторын ажлаас үүсэх чимээ шуугианы аюулгүй түвшинд хүртэл буурах зай буюу АТНБ-ийн радиус өдрийн цагаар 55.5 м, шөнийн цагаар 96.5 м нэгэн зэрэг 3 төрлийн эх үүсвэр ажиллах үед уулын техникийн хөдөлгүүрээс үүсэх чимээ шуугианы АТНБ-ийн радиус өдрийн цагаар 43.0 м шөнийн цагаар 75.5 м тус тус байна.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

“Бласт”ХХК-ийн “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, тэсрэх материалынн агуулах” цогцолборын талбай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт байрлана.

Улаанбаатар хотоос баруун урагш 900 км, Даланзадгад хотоос баруун зүгт 320 км, Гурвантэс сумаас зүүн урд зүгт 35 км, Шивээ хүрэн боомтоос 50 км зайд, Нарийн сухайтын уурхайн бүсэд байрлана. Тухайн төслийн нийт талбайн хэмжээ нь 10.086 га болно.

Тус нутаг дэвсгэр нь физик газарзүйн мужилалын хувьд Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид хамаарна. Газарзүйн хувьд Говь цөлийн бүсэд багтдаг. Гадаргын хэвгийн налуугийн ангилалаар 0-1 градус буюу хамгийн бага налуутай байна. Харин элсний мужлалаар Алтай өвөр говийн их мужийн Гурвантэс-Борзонгийн говийн дэд мужид багтана.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Тэсрэх бодисын агуулах болон үйлдвэрийн цогцолборын хэмжээнд чулуун хучаастай бор саарал болон сайр чулуурхаг бор саарал хөрс нам толгод, тэнш талархуу хэсгээр тархсан бол жижиг гуу, судаг, сайраар Сайрын хайргархаг болон элсэнцэр хөрс зохих салбарт тархсан. Үйлдвэрийн хашаа үйл ажиллагаа идэвхтэй явагдаж буй тэрхүү хэсэгт уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн хөрс зонхилох талбайг эзлэнэ. Тус объект онцгой статустай бөгөөд хашаалсан талбайн хэмжээний хөрс түүний орчмын гадаргыг хашаалж, ухаж хамгаалсан орчны бусад нөлөөллөөс сайтар хамгаалсан байна.

Тэсрэх бодисын үйлдвэр орчмын эвдэрсэн гадарга (Б-1)

Газар ашиглалт: үйлдвэрийн талбайн өмнөд хэсэгт, үйлдвэр байгуулах үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсний үржил шим бүхий өнгөн үе давхарга алдарч түүний оронд маш нягт бүтэцтэй суурь хурдас ил гарсан байдалтай байна. Үйлдвэрийн хашаалсан 3.35 га талбай нөлөөлөлд тодорхой хэмжээгээр өртсөн.

| Гүн см | pH _{H2O} (1:2.5) | CaCO ₃ % | Ялзмаг % | ЕС _{2.5} dS/m | Эзэлхүүн жин, г/см ³ | Ширхэгийн бүрэлдхүүн, % (хэмжээ мм-ээр) | | |
|--------|---------------------------|---------------------|----------|------------------------|---------------------------------|---|-------------------|----------------|
| | | | | | | Элс (2-0.05) | Тоос (0.05-0.002) | Шавар (<0.002) |
| 0-10 | 7.52 | 9.09 | 0.032 | 3.550 | - | 63.0 | 26.3 | 10.6 |

Хүснэгт: Хөрсний үндсэн шинж чанар (Б1)

- Хөдөлгөөнт элементүүдийн хэмжээ харилцан адилгүй буюу хангамжийн хувьд хэвийн байна (Кали 9.3 мг/кг, Фосфор 0.73 мг/кг).

Тэсрэх бодисын үйлдвэрийн цогцолборын хогын цэг (Б-2)

Газар ашиглалт: “Бласт”ХХК-ийн зүүн урд байрлалтай хогын цэгийг шинээр тохижуулж, хашаалах үйл ажиллагаагаар хөрсний үе давхарга алдарч түүний оронд суурь хурдас ил гарсан байдалтай байна.

| Гүн см | pH _{H2O} (1:2.5) | CaCO ₃ % | Ялзмаг % | ЕС _{2.5} dS/m | Эзэлхүүн жин, г/см ³ | Ширхэгийн бүрэлдхүүн, % (хэмжээ мм-ээр) | | |
|--------|---------------------------|---------------------|----------|------------------------|---------------------------------|---|-------------------|----------------|
| | | | | | | Элс (2-0.05) | Тоос (0.05-0.002) | Шавар (<0.002) |
| 0-10 | 7.32 | 1.82 | 0.153 | 3.580 | - | 60.1 | 30.7 | 9.2 |

Хүснэгт: Хөрсний үндсэн шинж чанар (Б2)

- *Хөдөлгөөнт элементүүдийн хэмжээ харилцан адилгүй буюу хангамжийн хувьд хэвийн байна (Кали 8.4 мг/кг, Фосфор 0.64 мг/кг).*

Тэсрэх бодисын агуулахын хашаан дотор (Б-3)

Газар ашиглалт: Тэсрэх бодисын агуулах байгуулах явцад хөрсний үржил шим бүхий өнгөн үе давхарга алдарч түүний оронд маш нягт бүтэцтэй суурь хурдас, чулуулаг ил гарсан байдалтай байна.

| Гүн см | pH _{H2O} (1:2.5) | CaCO ₃ % | Ялзма г % | ЕС _{2.5} dS/m | Эзэлхүүн жин, г/см ³ | Ширхэгийн бүрэлдхүүн, % (хэмжээ мм-ээр) | | |
|--------|---------------------------|---------------------|-----------|------------------------|---------------------------------|---|-------------------|----------------|
| | | | | | | Элс (2-0.05) | Тоос (0.05-0.002) | Шавар (<0.002) |
| 0-10 | 7.91 | 7.27 | 0.050 | 0.425 | 1.64 | 61.6 | 32.2 | 6.3 |

Хүснэгт: үндсэн шинж чанар (Б3)

- *Хөдөлгөөнт элементүүдийн хэмжээ харилцан адилгүй буюу хангамжийн хувьд хэвийн байна (Кали 7.2 мг/кг, Фосфор 0.51 мг/кг).*

Тэсрэх бодисын агуулхын хашааны гадна (Б-4)

Газар ашиглалт: тэсрэх бодисын агуулхын хашааны гаднах талбайд хамгаалалтын далангийн хэсгээс хөрсний дээжилт хийсэн. Агуулхын хашаанаас гадна тойруулан далан, шуудууг гадны нөлөөлөл, үер усны аюулаас тэсрэх бодисын агуулхыг хамгаалах, мал амьтан нэвтэрхээс сэргийлэн татсан.

| Гүн см | pH _{H2O} (1:2.5) | CaCO ₃ % | Ялзма г % | ЕС _{2.5} dS/m | Эзэлхүүн жин, г/см ³ | Ширхэгийн бүрэлдхүүн, % (хэмжээ мм-ээр) | | |
|--------|---------------------------|---------------------|-----------|------------------------|---------------------------------|---|-------------------|----------------|
| | | | | | | Элс (2-0.05) | Тоос (0.05-0.002) | Шавар (<0.002) |
| 0-10 | 7.49 | 4.00 | 0.239 | 2.436 | 1.41 | 63.5 | 27.8 | 8.7 |

Хүснэгт: Хөрсний үндсэн шинж чанар (Б4)

- *Хөдөлгөөнт элементүүдийн хэмжээ харилцан адилгүй буюу хангамжийн хувьд маш бага байна (Кали 8.7 мг/кг, Фосфор 63.5 мг/кг).*

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

- *Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гарах тоосоор тодорхой талбайн ургамал дарагдана*
- *Ургамлын төрөл зүйл хомсдох*
- *Тухайн нутгийн хувьд ургамлан нөмрөг байнга тачир сийрэг байдгийн дээр уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс эвдэрч элэгдэн ургамлын бүтэц тодорхой хэмжээгээр өөрчлөгдөн, тоос шороонд дарагдах, үрэгдэх зэргээр талхагдаж, ургаж хомсдоно*

- Ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай нэгдсэн хогийн цэгийн стандартын дагуу байгуулаагүйн улмаас байгаль орчинд хог хаягдал салхиар тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамлан бүрхэвчийг бохирдуулна
- Хүчтэй аадар борооны гадаргын урсац, нэг угаагдлаар ургамлан нөмрөг бохирдох, ургамлан бүрхэц багасах, зүйлийн бүрдлийн тоо цөөрөх, улмаар ургамлан нөмрөг устаж болзошгүй

Төслийн үйл ажиллагааны улмаас ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийн эрчим, хамрах хүрээ, хугацааг хүснэгтээр үзүүлэв:

| Нөлөөллийн эрчим Эх үүсвэр | Их | Дунд | Бага | Нөлөөллийн бүс | Нөлөөллийн үргэлжлэх хугацаа |
|---|--|---|-------------|----------------|------------------------------|
| Цогцолборын барилга байгууламжууд, хашаалсан талбай | 5.42 га талбай ихэнх хэсгийн ургамлан бүрхэвч үгүй болсон | Хашааны гадуурх шуудуунаас цааш, эргэн тойрон 20 м зайд талхагдах | 20-50 м-т | 50 м | Үйл ажиллагааны турш |
| Шороон зам | 1.6 км сайжруулсан шороон замаар байнга хийх тээвэрлэлтийн үед ургамал тоосонд дарагдах, талхагдах | Замаас хоёр тал руу 100 м зайд | 100-250 м-т | 250 м | |
| Хашааны гадуурах хамгаалтын шороон далан, үерийн шуудуу | 5.42 га талбайн гадуур татсан шуудуу, далан (дунджаар). Нийт 1375 м ² талбайн ургамал устсан, дарагдсан | 20 м зайд талхлагдах | 20-50 м-т | 50 м | |
| Дизель түлшний агуулах, нүхэн жорлон, хогийн цэг | Эх үүсвэр орчимд ургамал бохирдох, солигдох ургах | 3-5м радиуст бохирдох | 10 м | 10 м | |
| | - Гол сөрөг нөлөөлөл | | | | |
| | - Болзошгүй сөрөг нөлөөлөл | | | | |

Хүснэгт: Төслийн үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөл

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан дуу чимээ, тоос гарах, усны нөөц багасах, бэлчээрийн доройтол болох зэрэг сөрөг үзүүлэлт гарснаар зэрлэг ан амьтад мөн сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- *Зарим төрлийн шавьжийн амьдрах орчинг устгах*
- *Төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимийнээс амьтан, шувууд дайжих*
- *Төслийн зам тээврийн үйл ажиллагаанаас зарим амьтадын популяцын тусгаарлалт үүсэж, амьтдын нүүдэл мэдэгдхүйц сөрөг нөлөөлөл үзүүлнэ*
- *Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтдад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө.*

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Гадаргын ус – Төслийн талбай болон түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөхөөр гадаргын ус байхгүй болно

Газрын доорх ус – “Бласт”ХХК-ийн Нарийн сухайт салбар нь өөрийн мэдлийн 2 худагтай. Тус худгуудаас төслийн нийт усны хэрэгцээг хангадаг байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн газрын доорх усанд дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- *Газрын доорх усны нөөцийн хомсдол үүснэ*
- *Цэнгэг усны нөөцийг ашиглана*
- *Шатах, тослох материал, нефтийн бүтээгдхүүн, химийн бодис, бохир усны алдагдал, нэвчилтээс бага гүний уст үеүд бохирдох*
- *Хаягдал ус цэвэршүүлэх байгууламжид гарч болзошгүй эвдрэл гэмтэл нь цэвэршүүлээгүй усыг байгальд хаяж, ингэснээр бохир ус газрын доорх усанд нэвчин бохирдуулах*
- *Тус тэсрэх бодисын үйлдвэр, агуулхын цогцолбор нь унд-ахуйн хэрэгцээндээ жилд 4088 м³, үйлдвэрлэлийн хэрэгцээнд жилд 9125 м³ ус хэргэлдэг байна. Жилд ойролцоогоор 13213 м³ ус хэргэлдэг*
- *Тухайн цогцолбор нь бохир усаа Гурвантэс сумын “Шугшаа уул” ОНӨААТҮГ – ын харьяа цэвэрлэх байгууламжид гэрээгээр нийлүүлдэг*

Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн талбай нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газар хамаарахгүй болно.

“Бласт”ХХК-ний Нарийн сухайт салбарын талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт давхцалгүй байна.

Түүх соёлын дурсгалт зүйлсэд нөлөөлөх байдал, үнэлгээ

Төслийн талбайн болон түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс байхгүй байна.

Төсөл хэрэгжүүлэх явцад мэдэгдээгүй түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хирэгсүүр, археологи, палеонлогийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож хамгаалалт гарган зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгуулгад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хамгаалалтанд авах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдал

Төсөл хэрэгжих Гурвантэс сум нь нийт 2,796,727 га газар нутагтай. Засаг захиргааны анхан шатны нэгж болох 5 багтай. Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй. Сумаас 55 км-т Дундголын давсны уурхайгаас “Говь гурван сайхан ХХК”, “Асралт ХХК”, “Сондог нөхөрлөл” нь жилдээ 220 орчим тн давс олборлож борлуулдаг ба сумаас 25 км-т орших нүүрсний уурхайнууд нь жилдээ 1722.8 мянган тонн нүүрс олборлон БНХАУ-д экспортолж байна.

Сумын газар нутгийн ихэнх хэсэг нь олон сая жилийн өмнө амьдарч байсан аварга үлэг гүрвэлийн орон гэгдэх бөгөөд ховор нандин олдвороороо гадаад дотоодын эрдэмтдийн анхаарлыг татаж Зөвлөлт, Польш, Монголын палентологичид хайгуул шинжилгээ хийж тэдний ажил шинэ шинэ олдвороор баяжсаар ирсэн юм. Энэхүү олдворууд нь Москва, Варшав, Улаанбаатар, Даланзадгадын музейд өнө эртний аварга денозвар болон сүндэрлэж чимэг болж байна.

Мөн сайн чанарын чулуун нүүрс, давсаар баялаг, алт, төмрийн хүдэр, барилгын сайн чанарын шохой, шохойн чулуу, төрөл бүрийн өнгийн шороон будаг болон гартаам, мана зэрэг үнэт чулуу элбэг тохиолдоно.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- *Төслийн үйл ажиллагаа, тээвэрлэлтээс дэгдэх тоос нь орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд шууд сөргөөр нөлөөлөл үзүүлнэ*
- *Төслийн аюулгүйн ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд аюул учрах зэрэг болно*
- *Төслийн үйл ажиллагааны горим алдагдсанаас ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд авул учрах*
- *Төслийн дотоод ба гадаад тээвэрлэлтийн буруу зохицуулалт, үйл ажиллагаанаас ослын төвшин нэмэгдэх*
- *Үйлдвэрлэлийн ослын эрсдэл нэмэгдэнэ*
- *Төслийн хөдөлмөрийн аюулгүйн байдлаас болж хүмүүс бэртэх*
- *Нутгийн иргэдийн малын бэлчээр төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд өртөнө*

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

“Бласт”ХХК-ийн Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийн сухай дахь “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тухайн төслийн хэрэгжилтийн явцад авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Бласт”ХХК тэсрэх бодисын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилготой. “Бласт”ХХК тэсрэх бодисын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцож буй нийт ААН-д байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдүүлнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорино. Үүнд:

- *“Бласт”ХХК-ийн байгаль орчны бодолгыг хэрэгжүүлэх*
- *Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй ААН, байгууллагуудын газар ашиглалтын үйл ажиллагаанд байгаль орчны хяналт тавих, хамтран ажиллах*
- *Байгаль орчны үнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх*
- *Үйлдвэрийн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах*

Хөрөнгө санхүү

“Бласт”ХХК-ийн үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөнд байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тусгаж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажиглалт хяналт явуулах шаардлага

- Төслийн хугацаанд мэргэжлийн байгуулгаар агаар, хөрс, усны сорьц, дээж авах болон шинжилгээ хийлгэж зөвөлгөө авч байх
- Төслийн хугацаанд ажилчдын эрүүл мэндийг мэргэжлийн эмч нарт үзүүлж мэргэжлээс шалтгаалах өвчнүүдийг эмчийн хяналтанд авч байх
- Аюулгүй ажиллагааны дүрэм журмын хэрэгжилтийг хянаж байх

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Нийт зардал /сая.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|------------------|---|--|--|--------------------------------------|-----------------------|--------------------------------|--|
| 1.1 Агаар | | | | | | | |
| 1.1.1 | Хур тунадасгүй хуурайшил ихтэй үед машин техникийн хөдөлгөөнөөр агаарт тоос дэгдэх | Сайжруулсан замын усалгаа хийх | Цогцолборын хэмжээн дэх сайжруулсан зам | Цаг агаарын хуурайшилтаас шалтгаалах | Үйлдвэрийн зардлаас | Үйл ажиллагааны туршид | “Агаарын тухай” хууль MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. |
| 1.1.2 | Үйлдвэрийн байр ба агуулахад түүхий эд /аммиакийн шүү/ агаарт дэгдэх, ажилчдыг хордуулах | Агаарын чанарын хэмжилтийг хийх | Лицензийн талбайд | үзүүлэлт | ОХШХ | Жилд 1 удаа | MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. |
| 1.1.3 | Суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмж, уурын зуухны яндангаас гарах хий агаарын чанарт нөлөөлөх | Тоног төхөөрөмж болон зуухны төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийх, | Уурхайн зуух, хөдөлгөөнт болон суурийн тоног төхөөрөмж орчим | Үзлэг давтамж | Дотоод үйл ажиллагаа | Сар бүр | Агаарын тухай хууль, холбогдох стандарт |

Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Хэрэгжүүлэх хэлбэр | Арга хэмжээний цар хүрээ | Тоо хэмжээ /хэмжих нэгж/ | Нийт зардал /сая.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|--------------------------|---|--|--------------------------|--------------------------|-----------------------|--------------------------------|--|
| 1.2 Хөрсөн орчинд | | | | | | | |
| 1.2.1 | Хөрс бохирдох | Хөрсний шинжилгээг гэрээт байгууллагаар шинжлүүлэх, дата үүсгэх | Мониторингийн цэгүүдэд | жилд 1 удаа | 0,4 | Үйл ажиллагааны туршид | MNS 5850:2008. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| 1.2.2 | Хог хаягдлын түр цэгээс шалтгаалан хөрс бохирдох | Хог хаягдлыг түр цэгт хаяхдаа зохих журмын дагуу ангилан ялгаж, ахуйн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт Шугшаа уул ОНӨААТҮГ гэрээ байгуулан нийлүүлэх | Хаягдлын цэг орчим | м ³ | Дотоод үйл ажиллагаа | Үйл ажиллагааны туршид | |
| 1.2.3 | Тос, тосолгоо, түлш, хөрсөнд асгарч хөрсийг бохирдуулах | ШТС-г шинээр ашиглалтанд оруулах, байнгын хяналтад байлгаж өдөр тутмын хяналтын хуудасны дагуу үзлэг хийх | ШТС орчим | Үзлэг давтамж | Дотоод үйл ажиллагаа | Өдөр бүр | |
| 1.2.4 | Төслийн талбайд хог хаягдлыг ил задгай хаях, хөрс бохирдуулах | Үндсэн болон гэрээт компанийн ажилчдад хог хаягдлын менежментийн сургалт орох | Төслийн талбай орчимд | Сургалт х.тоо | Дотоод үйл ажиллагаа | Жил 2 удаа, Шинэ ажилтан бүрт | |
| 1.2.5 | | Ангилсан хогийн цэгийн ойр орчмыг халдваргүйжүүлэх | Шаардалатай цэгүүдэд | Талбайн | Дотоод үйл ажиллагаа | Жилд 2 | |

Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“БЛАСТ”ХХК-ний “Нарийн сухайт” салбарын “Тэсрэх бодис хольцын үйлдвэр, тэсрэх материалын агуулах цогцолбор” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Хэмжих нэгж | Нийт зардал /сая.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|------------------------|---|--|------------------------------|----------------------|--------------------------|--------------------------------|--|
| 1.3 Усан орчинд | | | | | | | |
| 1.3.1 | Гүний ус болон унд ахуйн цэвэршүүлсэн ус бохирдох | Хими бактерилогийн шинжилгээ хийлгэх | Худаг1, Худаг3, | 4 удаа | 0,4 | Улирал тутамд | Ундны ус, эрүүл ахуйн шаардлага MNS 900:2010 |
| 1.3.2 | Өрөмдлөг худагын усны түвшинд | Гүний худгийн түвшин хэмжилт хийх /хяналт тавиж ажиллах/ | Худаг1, худаг3 | Үйл ажиллагааны турш | - | 2023 онд | |
| 1.3.4 | Усны илүү ашиглалт | Сар болгоны 25-нд ус ашиглалтын тоолуурын баталгаажуулалт хийх | Цогцолборын худаг | 12 удаа | - | 2023 онд | |
| 1.3.5 | Булгийн эхийг хамгаалах | Компанийн хашиж тохижуулсан 3 булгийн эхийн хашааг засаж, тордох | Зүүнтүрүү Хөөвөр Хошуу булаг | 1 удаа | Үйл ажиллагааны зардлаас | 2023 онд | |
| 1.3.6 | Усны илүү ашиглалт | 10 сарын 26нд унд ахуйн худгын тоолуурын баталгаажуулалт хийх | Худаг-3 | 1 удаа | - | 2023 онд | |
| 1.3.7 | Газрын доорх усны нөөцөд нөлөөлөх | Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ хийх | Цогцолборын худаг | 1 удаа | ОХШХ зардлаас | 2023 онд | |

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Тоо хэмжээ /хэмжих нэгж/ | Нийт зардал /сая.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
